



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/003/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.08.24 № 360
танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ИЧИНХОРЛОО ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хангал сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор санхүүгийн нэгдсэн тайлангаар авлага 4.5 хувь буюу 2,743.6 мянган төгрөгөөр барагдаж, өглөг 11,959.6 мянган төгрөг буюу 80.1 хувиар буурсан, батлагдсан төсвөөс зардлыг 488,826.8 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг харгалзаж үзнэ.

Хангал сумын ТТЗ нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 4,174,301.5 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 4,284,546.6 мянган төгрөгөөр буюу 110 хувиар биелүүлсэн байна.

632502700

Бусад асуудлын хэсэг

Хангал сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээгээр 2024 онд 148 ажил төлөвлөснөөс 139 ажлыг гүйцэтгэж гүйцэтгэлийн биелэлтийг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	619.8	785.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,167.6	2,612.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,787.4	3,397.3
Нийт өр төлбөрийн дүн	14.9	3.0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,772.5	3,394.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,787.4	3,397.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	4,524.9	5,198.8
Үйл ажиллагааны зардлын дүн	2,928.0	3,237.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,596.9	1,961.1
Үйл ажиллагааны бус үр дүн	(572.2)	(1,339.2)
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,024.7	621.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/		
Дархин илэрхийлсэн үлдэгдэл	1,747.7	2,772.5
Тайлант оны үр дүн	1,024.8	621.9
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,772.5	3,394.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,730.2	4,729.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,719.1	3,092.7
Үйл ажиллагааны мөнгөн ЦМГ	1,011.1	1,636.5
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	828.6	1,368.7
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(828.6)	(1,368.7)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	(59.4)	(29.4)
Нийт ЦМГ	123.1	238.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	123.1	238.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,049.9
Урсгал зардал		1,762.9
Хөрөнгийн зардал		1,257.6
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл		29.4
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		3,049.9
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		2,958.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		167.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		177.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		253.3

Гурав.Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангал сумын ЗДТГ нь “Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх , үйл ажиллагааны удирдлагыг тасралтгүй хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжихэд оршино гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эдийн засаг, санхүүгийн стратегийн төлөвлөлт бодлогын шийдвэр боловсруулахад дэмжлэг үзүүлэх.
- Салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын шийдвэр боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх.
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах.
- Иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

ТЕЗ-ийн нэгдсэн тайланд тусгуулах:

1.Байгаль хамгаалах санд өвс бэлтгэж иргэдэд зарж борлуулсны үнийг төвлөрүүлж байгаа нь “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх тайлагнах журам”-тай нийцэхгүй байгаад харьяа дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.Зохих шатны шийдвэр, эрх зүйн үндэсгүйгээр аж ахай нэгж байгууллагатай ЗДТГ гэрээ байгуулан сумын бэлчээр буюу өвсний гарц ихтэй газрыг түр хугацаанд ашиглуулан өвс бэлтгүүлэн гэрээнд заасан 6.0 сая төгрөгийн байгаль хамгаалах санд төлбөрийг төвлөрүүлж хүү торгуулийн дансруу шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 6.2, 52 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд¹ 6.91 сая төгрөгийн 1 албан шаардлага өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 35.5 сая төгрөгийн зөрчилд² 25.2 сая төгрөгийн 1 алдааг илэрснээс, 3.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 3.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

5.1. Албан шаардлага

1. Байгаль хамгаалах санд төвлөрч байгаа өвсний үнээс 6.9 сая төгрөгийн нэг наст ургамал худалдан авч зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй мөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн ажиллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	25.2	1	25.2			1	25.2				
ИТХ												
ХХС												
ОНХС												
Дүн	1	25.2	1	25.2			1	25.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	1	6.91			1	6.91						
ЗДТГ	6	6.2	2	2.3	2	3.88	2					
ИТХ	3	3.44	1	0.54			2	2.9				
ХХС	0	0										
Дүн	10	16.55	3	2.86	3	10.79	4	2.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ								
ОНХС								
ХХС								
ИТХ								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0.86	1	0.86				-
ОНХС	1	16.00			1	16.00		-
ИТХ	1	0.23	1	0.23				
Нийт дүн	3	17.09	2	1.09	1	16.00		-

